ШИНЭ КОРОНОВИРУСТ ХАЛДВАР (SARS-COV-2)-ЫН ҮЕД ЭМЧЛҮҮЛЭГСЭД, ТУСГААРЛАЛТАД БАЙГАА ИРГЭД СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВД ХАНДАН ТУСЛАМЖ АВСАН БАЙДАЛ

Э.Мөнх[1], Б.Лувсанняндаг[1], Д. Оюунсүрэн[2], Р.Оюунгэрэл[2], З.Хишигсүрэн[2]

[1]Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв
[2]АШУҮИС, Анагаах ухааны сургууль
munkh@gtc.mnuns.edu.mn

Түлхүүр үг:
Ковид-19, сэтгэл гутрал, сэтгэл түгшилт, сэтгэцийн эмгэг, нойргүйдэл

Товч утга: Үндэслэл: 2019 оны сүүлээр БНХАУ-ын Ухань хотод анх бүртгэгдсэн шинэ коронавирус (SARS-CoV-2)-т халдварын дэгдэлт богинохон хугацаанд дэлхий дахинаа тархаж цар тахлын түвшинд хүрсэн. Цар тахалтай холбоотойгоор дэлхийн нийт хүн амын дунд сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлууд үүсч байгаа тул хүн амд сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ зайлшгүй шаардлагатай болохыг ДЭМБ-аас онцолж байгаа билээ. Иймд бид эмчлүүлэгсэд, тусгаарлалтад байгаа иргэд сэтгэцийн эрүүл мэндийн тусламж авсан байдлыг судлахыг зорилоо. **Ёс зүй:** Судалгааны ажлыг ЭМЯ-ны Ёс Зүйн Хяналтын Хорооны 2020 оны 7-р сарын 8-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж судалгаа хийх ёс зүйн зөвшөөрөл авсан болно. **Арга зүй:** Цар тахлын үеийн халдвар хамгааллын дэглэмтэй холбоотойгоор цахим аргаар судалгааг хийв. **Үр дүн:** Дэлхий дахинаа SARS-CoV-2 вирүсийн халдвар тархсанаас хойш буюу 2020 оны 3-р сарын 28-наас 9-р сарын 20 хүртэлх хугацаанд ХӨСҮТ болон Жаргалант, Сэнтий, Сүнжин Гранд, Тайж, Монголика зэрэг тусгаарлах байранд тусгаарлалтанд байгаа нийт 25 иргэнд 40 удаагийн ганцааарчилсан зөвлөгөө, эмийн эмчилгээний заалт бичиж, эргэн холбоо тогтоож эмчлэгч эмчид утсаар зөвлөгөө өгсөн байна. Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авсан эмчлүүлэгч, тусгаарлагсдын дунд сэтгэл түгших хамшинж (24%, n=6), хий үзэгдэл дэмийрлийн хамшинж (20%, n=5)-тэй үйлчлүүлэгчид хамгийн их хувийг эзэлж байв. **Дүгнэлт:** Сэтгэцийн эмгэгийн түгээмэл хамшинж илэрсэн эмчлүүлэгсэд, тусгаарлагсдад эмийн эмчилгээ хийж, ганцааарчилсан зөвлөгөө өгсөн байна.

Судалгааны үндэслэл: 2019 оны сүүлээр БНХАУ-ын Ухань хотод анх бүртгэгдсэн шинэ коронавирус (SARS-CoV-2)-т халдварын дэгдэлт богинохон хугацаанд дэлхий дахинаа тархаж цар тахалд шилжсэнээр өнөө хүртэл хүн төрөлхтний эрүүл мэнд болон эдийн засгийн салбарт ихээхэн хор хөнөөл учруулсаар байна[1]. SARS-CoV-2 шинэ вирүсийн халдварт өртөхөөс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний хүрээнд улс орнууд хөдөлгөөн хязгаарласантай холбоотойгоор бидний өдөр тутмын амьдралд маш их өөрчлөлт гарч байгаа билээ.[2] Хятад улсад хаврын баярын үеэр аялал жуулчлалыг хориглох, хорио цээрийн дэглэмд шилжүүлэх, Ирак улсад хөл хорионы үеэр нийгмийн сүлжээгээр цацагдаж буй мэдээлэлтэй холбоотойгоор иргэдийн дунд сэтгэлт түгшилт үүсгэж байгааг тогтоожээ. Цахим орчинд цаг их зарцуулах тусам сэтгэлзүйд дарамт учруулж, сэтгэцийн эмгэгт өртөх эрсдэл өндөр байна гэж эрдэмтэд үзжээ.[3-4] Тусгаарлалт, түр хугацаагаар ажилгүй болох, орлого буурах, халдвар авахаас айх айдас зэрэг хүчин зүйл нь сэтгэцийн тулгамдсан асуудал үүсэхэд нөлөөлж байна.[5] Нийгэм, ажил мэргэжлийн орчин өөрчлөгдсөн энэ цаг үед сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал, сэтгэцийн өвчлөл, ялангуяа согтууруулах болон мансууруулах бодисын хэрэглээ, нойрны хямрал, айдас түгшүүрийн эмгэг ихэснэ гэж сэтгэцийн эрүүл мэндийн мэргэжилтнүүд таамаглаж байв.[2,5] Цартахлын улмаас хөл хорио тогтоосон энэ цаг үед хүн амын дунд өөрийгөө гэмтээх зан үйл, гэр бүлийн хүчирхийлэл, мансууруулах бодис хэрэглэх, дэлгэцийн донтолт, ганцаардал, сэтгэл гутрал болон сэтгэл түгших эмгэг зэрэг нь дэлхийн хэмжээнд мэдэгдэхүйц нэмэгджээ.[6]

Дэлхий нийтэд цар тахлын улмаас сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний эрэлт нэмэгдсэн[5] ба манай улсын хувьд 2020 оны 3-р сарын 10-нд SARS-CoV-2 вирүсийн халдвартай зөөвөрлөгдсөн

анхны тохиолдол бүртгэгдсэн цаг үеэс сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хэрэгцээ нэмэгдэж буй нь ажиглагдсан. СЭМҮТ-өөс УОК-той хамтран тусгаарлалтад буй иргэдэд зориулан айдас түгшүүрийг даван туулах, нойрны хямрал, уур бухимдлаа зохицуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор тусгайлан зөвлөмж боловсруулан түгээж байсан билээ. Иймд бид хөл хорионы үед эмчлүүлэгсэд, тусгаарлагсдаас сэтгэцийн нарийн мэргэжлийн эмчид хандан тусламж үйлчилгээ авсан байдлыг судлах хэрэгцээтэй гэж үзлээ.

Судалгааны ажлын ёс зүй: Судалгааны ажлыг ЭМЯ-ны Ёс Зүйн Хяналтын Хорооны 2020 оны 7-р сарын 8-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж (2020 оны 7-р сарын 8-ны тогтоол № 172) судалгаа хийх ёс зүйн зөвшөөрөл авсан болно.

Судалгааны материал арга зүй: Судалгааг эмчлүүлэгсэд болон тусгаарлалтад буй хүмүүсээс сэтгэцийн эрүүл мэндийн зөвлөгөө, тусламж авагсдын бүртгэлийн баримтад тулгуурлан баримтын судалгааны аргаар хийв.

Судалгаанд хамрагдах баримтыг сонгох шалгуур: 2020 оны 3-р сарын 28-наас 9-р сарын 20 хүртэлх хугацаанд *SARS-CoV-2* вирүст халдвартай болох нь батлагдсан, тусгаарлалтад байгаа иргэдээс сэтгэцийн эрүүл мэндийн тусламж авсан тохиолдлуудын бүртгэлийн баримтыг сонгов.

Судалгааны зорилго: Шинэ коронавирүсийн халдвар (*SARS-COV-2*)-ын үед эмчлүүлэгсэд, тусгаарлагсдын сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авсан байдлыг судлахад оршино.

Зорилт:

1. Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авсан эмчлүүлэгсэд, тусгаарлагдагсдын тухайн үеийн сэтгэцийн байдлыг судлан тогтоох
2. Эмчлүүлэгсэд, тусгаарлагдагсдад үзүүлсэн сэтгэцийн эрүүл мэндийн тусламжийн хэлбэрийг судлан тогтоох


Үр дүн: Судалгаанд 2020 оны 3-р сарын 28-наас 9-р сарын 20 хүртэлх хугацаанд ХӨСҮТ-д эмчлүүлж буй 7, Цэргийн төв эмнэлэгт тусгаарлалтад буй 3, гэрийн хорионд буй 2, Ивээлэн, Жаргалант, Сэнтий, Сүнжин гранд, Тайж, Монголика зэрэг амралт, сувиллын газар, зочид буудалд тусгаарлалтад буй 13, нийт 25 иргэнд 40 удаагийн сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн байдлын бүртгэлд баримтын судалгаа хийлээ. Баримтын судалгааны дүнгээс үзвэл 14-73 насны иргэд сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авсан байна.

Хүснэгт 1. Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авагсдын нас, хүйсийн байдал

Насны бүлэг	Хүйс		N	%
	Эрэгтэй	Эмэгтэй		
18-аас доош	1	0	1	4
19-25	1	2	3	12
26-30	4	2	6	24
31-35	2	0	2	8
36-40	3	1	4	16
41-45	1	1	2	8
46-50	1	2	3	12
51-55	0	0	0	0
56-60	0	0	0	0
60 -аас дээш	2	2	4	16
Нийт	15(60%)	10(40%)	25	100

Хүснэгт 1-ээс үзвэл сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авагсдын 60%(n=15) нь эрэгтэй, 40% буюу 10 тохиолдол нь эмэгтэйчүүд, насны бүлгээр үзвэл 26-30 насны бүлэгт илүү хувийг (24%) эзэлж байсан бол 51-60 хүртэлх насны бүлэгт сэтгэцийн эрүүл мэндийн тусламжинд хандсан үйлчлүүлэгч үгүй байна. Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж авсан иргэдийн 2 нь гадаадын иргэд байв. Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж авсан давтамжийг судлан үзвэл хоёр удаа зөвлөгөө авсан 4, гурван удаа зөвлөгөө авсан 3, дөрвөн удаа зөвлөгөө авсан 2 тохиолдол байх бөгөөд зөвлөгөө авсан бүх хүмүүст сэтгэц нөлөөт эмийн эмчилгээ зааж, тусгаарлалтаас гарсны дараа сэтгэцийн эмчид үзүүлж зөвлөгөө авах, хяналтын эмчидүзүүлэх талаар мэдээлэл, зөвлөгөө өгсөн байлаа.

Сэтгэцийн эрүүл мэндийн тусламжинд хандсан бүх үйлчлүүлэгчид тухайн үеийн сэтгэцийн байдлыг тодорхойлох үзлэг хийж хамшинжийн оноош тавьсан байна.



Зураг 1. Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авагсдын сэтгэц эмгэгийн хам шинж

Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авсан эмчлүүлэгч, тусгаарлагсдын сэтгэц эмгэгийн хам шинжийн оноошийг авч үзвэл хамгийн их хувийг сэтгэл түгших хам шинж (24%, n=6), хий үзэгдэл дэмийрлийн

хам шинж (20%, n=5)-тэй үйлчлүүлэгчид эзэлж байна. 2 (8%) үйлчлүүлэгч архины шалтгаант солиоролтой байсан бөгөөд нэг үйлчлүүлэгч нь согтуугаар унаж хөлөө гэмтээсэн байсан тул Цэргийн төв эмнэлэгт тусгаарлагдаж байжээ (Зураг 1).

Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авсан нийт 25 тохиолдлын 3 нь урьд нь сэтгэцийн эмгэгтэй болох нь оношлогдсон өвчтөн байсан байна. Баримтын судалгаанаас үзвэл сэтгэл гутрах хам шинж илэрсэн нэг үйлчлүүлэгч нь уушгины сүрьеэ, чихрийн шижин зэрэг хавсарсан өвчтэй, сэтгэл түгших эмгэгтэй 6 тохиолдол нь хавсарсан органик өвчин үгүй гэсэн байна. Сэтгэл түгших хам шинж бүхий үйлчлүүлэгчид нь 29-62 насны, хүйсийн хувьд эрэгтэй 3, эмэгтэй 3 тохиолдол байлаа.

Хэлцэмж: Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авсан хүмүүст хүн амын дунд зонхилон тохиолдох эмгэгийн үед түгээмэл илэрдэг 10 гаруй хам шинж илэрсэн байна. Үйлчлүүлэгчдэд илэрсэн сэтгэц нөлөөт эмийн гаж нөлөө, хий үзэгдэл дэмийрлийн хамшинж, кататоник хамшинж, архины шалтгаант солио зэрэг сэтгэц эмгэгийн хам шинжийн байдлыг судлан үзвэл урьд нь сэтгэцийн эмгэгтэй байсан байх магадлал их тул үйлчлүүлэгчдэд тухайн нөхцөл байдлын улмаас илэрсэн шинж тэмдэг үү, урьд нь оношлогдсон өвчтэй хүн байсан уу гэдгийг ялган тогтоох зайлшгүй шаардлагатай байна.

Судалгаанд хамрагдагсдын 6 нь сэтгэл түгших хам шинжтэй, асуумжаар органик өвчин үгүй гэж хариулсан байдлаас үзвэл тухайн нөхцөл байдалтай холбоотой сэтгэлийн шалтгаант сэтгэл түгшилт байх магадлалтай хэдий ч цаашид өвчин даамжирч айдас түгшүүрийн эмгэг, улигт байдал, сандрах эмгэг, сандрах эмгэгийн дайралд өртөх зэрэг хүндрэлээс урьдчилан сэргийлж нарийн мэргэжлийн эмчид хандан оношийг ялган тогтоох, зөвлөгөө авах шаардлагатай гэж үзэж байна. Түүнчлэн сэтгэл түгшилт нь дэлхий дахинаа хүн амын дунд зонхилон тохиолдох эмгэгийн тоонд ордог, нөгөө талаас хүний эрүүл мэндийн асуудал нь хүчтэй стрессор болдог тул сэтгэл түгших хариу урвалын түвшинд илэрч байж болох юм гэж үзлээ. Хятад улсад хийгдсэн судалгаанд сэтгэц эмгэгийн хамшинжүүдийн давтамжийг судлан үзэхэд сэтгэл түгших хамшинж хамгийн их байжээ.[7] Мөн хүн амд суурилсан судалгаанд эмэгтэй хүйс, оюутан байх, *SARS-CoV-2* шинэ вирүст халдварын шинж тэмдэг илэрч биеийн байдал муу байгаа нь сэтгэл түгшилт, сэтгэл гутрал өндөр түвшинд байхтай холбоотой байна гэжээ.[8] Иймд *SARS-CoV-2* шинэ вирүст халдвараар өвдсөн, өвчлөөд эдгэрсэн, тусгаарлалтад буй иргэдийн сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг судлах нь чухал юм.

2020 оны 2-р сарын 18-ны өдөр Хятадын Үндэсний эрүүл мэндийн хорооноос сэтгэцийн өвчтэй 323 хүнд *SARS-CoV-2* шинэ вирүст халдвар оношлогдсон гэж мэдээлжээ.[9] Харин бидний судалгаанд сэтгэцийн эрүүл мэндийн тусламж авахаар хандсан 25 тохиолдлын 3 нь урьд нь сэтгэцийн өвчтэй байсан нь тогтоогдсон байсан ба манай улсад хүн ам цөөтэй, дотооддоо халдвар тархаагүй, сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авсан тохиолдлын тоо цөөн гэх мэт олон хүчин зүйлээс хамаарч өөрийн орны мэдээллийг Хятад улсын мэдээлэлтэй харьцуулахад өрөөсгөл юм. Гэвч цаашид *SARS-CoV-2* шинэ вирүст халдвар оношлогдсон болон тусгаарлах байруудад сэтгэцийн өвчтэй иргэдийн тоо өсөн нэмэгдсэн тохиолдолд тэдний хавсарсан өвчлөлийг эмчлэхээс гадна сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг аюулгүй зохион байгуулахад бэрхшээл үүсэхийг үгүйсгэхгүй юм.Тухайлбал: тусгаарлагсдад сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үзүүлсэн сэтгэцийн эмчийн ярилцлагаас үзвэл хий үзэгдэл дэмийрлийн болон архины шалтгаант солиоролтой үйлчлүүлэгчийг 2-оос дээш давхарт байрлуулсан байсан нь үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангахад төвөг учруулж байсан гэжээ. Иймд цаашид сэтгэцийн эмгэгтэй, сэтгэцийн тулгамдсан асуудалтай эмчлүүлэгсэд болон тусгаарлалтад байгаа сэтгэцийн эмгэгтэй иргэдийг нийгэмд аюултай үйлдэл хийхээс урьдчилан сэргийлэх ажлын зохион байгуулалтанд анхаарах ёстой асуудлын нэг мөн гэж үзэж байна. Сэтгэц эмгэгийн хамшинж илэрч байгаа, SARS-CoV-2 шинэ вирүст халдварын оношлогдсон батлагдсан болон сэжигтэй тохиолдлуудад сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг давтан үзүүлэх шаардлагатай байдаг тул сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж буй эмч, эмнэлгийн ажилчдын халдвар хамгааллын асуудлыг зайлшгүй анхаарах шаардлагатай гэж үзэж байна. Энэхүү судалгааны хязгаарлагдмал тал нь цар тахлын үеийн халдвар хамгааллын дэглэм, тусгаарлалтын дэглэмтэй холбоотойгоор сэтгэц эмгэгийн хамшинж илэрсэн өвчтөнүүдэд өдөр бүр сэтгэцийн эмчийн үзлэг хийх, харилцан ярилцах боломжгүй байсанд оршино.

Дүгнэлт:

1. Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авсан Ковидын халдвартай эмчлүүлэгсэд, тусгаарлагдагсдын дунд сэтгэцийн эмгэгийн түгээмэл 11 хамшинж илэрсэнээс сэтгэл түгших хамшинж (24%), хий үзэгдэл-дэмийрлийн хамшинж (20%) хамгийн их хувийг эзэлж байна.
2. Сэтгэцийн эмч нь сэтгэц эмгэгийн хамшинж илэрсэн эмчлүүлэгч, тусгаарлагдагсдад тухайн үеийн сэтгэцийн байдлыг тодорхойлох үзлэг хийх, хамшинжийн оношлогоо тавих, эмийн эмчилгээний заалт гаргах, ганцаарчилсан зөвлөгөө өгөх, эргэх холбоо тогтоож эмчлэгч эмчид эмчилгээний талаар зөвлөгөө өгөх, давтан үзлэг хийж сэтгэцийн байдлыг хянах зэрэг тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.

Ном зүй:

1. *Tu YF, Chien ChSh, Aliaksandr AY, et all. A review of SARS-CoV-2 and the ongoing clinical trials: Int.J.Mol.Sci. 2020;21:2657. doi:10.3390/ijms21072657*
2. *WHO, Healthy at home-Mental health*
3. *Bao Y, Sun Y, Meng S, Shi J, Lu L. 2019-nCoV epidemic: address mental health care to empower society. Lancet. 2020;395(10224):e37□e38. doi:10.1016/S0140-6736(20)30309*
4. *Д.Гэрэлмаа. Олон улсад хийгдсэн судалгааны товч мэдээлэл. Халдарт өвчин судлалын Монголын сэтгүүл. 2020:4(93):65-67*
5. *WHO. Covid-19 disrupting mental health services in most countries, WHO survey. http://www.who.int/news-room/detail/05-10-2020-covid-19-disrupting-mental-health-servies-in-most-countries-who-survey*
6. *Tandon R. COVID-19 and mental health: preserving humanity, maintaining sanity, and promoting health. Asian J. Psychiatry. 2020;51. doi.org/ 10.1016/j.ajp.2020.102256.*
7. *Rajkumar RP. COVID-19 and mental health: A review of the existing literature. Asian J. Psychiatry. 2020;52:102066. doi.org/10.1016/j.ajp.2020.102066*
8. *Wang C, Pan R, Wan X, Tan Y, Xu L, Ho CS, er all. Immediate Psychological Responses and Associated Factors during the Initial Stage of the 2019 Coronavirus Disease (COVID-19) Epidemic among the General Population in China. Int. J. Environ. Res. 2020;17(1729):2-25. doi:10.3390/ijerph17051729*
9. *Xiang YT, Zhao Y, Lui ZH, Li XH, Zhao N, Cheung T, et all. The COVID-19 outbreak and psychiatric hospital in China: managing challenges through mental health service reform. Int. J. Biol. Sci. 2020;16(10):1741-1744. doi:10.7150/ijbs.45072*

THE SITUATION FOR SEEKING HELP FROM THE NCMH OF INPATIENTS AND ISOLATED PEOPLE WITH NEW CORONAVIRUS (SARS-COV-2) INFECTION

Munkh E[1], Luvsannyandag B[1], Oyunsuren D[2], Oyungerel R[2], Khishigsuren Z[2]

[1]National Center for Mental Health
[2]School of Medicine, MNUMS
munkh@gtc.mnums.edu.mn

Background: Outbreaks of the new coronavirus (SARS-CoV-2) infection, which began in late 2019 in Wuhan, China, quickly spread around the world and reached pandemic levels. The WHO emphasizes the need for mental health care for the world's population due to the growing number of mental health problems associated with the pandemic. Therefore we aimed to define the situation of receiving mental health care from isolated people and inpatients (isolated after treatment course)

Ethics: Ethical approval was obtained from the Medical Ethics Review Committee under the Ministry of Health on July 08, 2020.

Methodology: The study design was descriptive and cross-sectional. We used electronic technology for collecting data due to pandemic infection control regimes.

Result: Since the outbreak of the new SARS-CoV-2 virus infection worldwide, from March 28 to September 20, 2020, a total of 25 cases, who have been treating in the NCCD or isolated in other isolation & observation places (such as Jargalant, Sentii, SunjinGrand, Taij and Mongolica etc) were provided necessary mental health care (such as individual counseling, psychotropic treatment, feedback with the case, and hot-line counseling for physicians etc) for 40 times. Among total cases receiving mental health care, the majority were with anxiety syndrome (n=6, 24%) and paranoid syndrome (n=5, 20%).

Conclusion: Psychotropic treatment and individual counselling provided for COVID-infected inpatients and isolated people with most common psychiatric syndroms.

Keywords: COVID-19, depression, anxiety, mental disorders, insomnia